

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/04-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Баасансүрэн
Утас: 70362442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9-20
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9-10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10-11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-20
4. Аудитын тайлан	20-27
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20-21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21-22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22-23
5. Аудитын илрүүлэлт	23-26
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.СЭРГЭЛЭН ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № СЭА-2024/04-НА-СТА-ТТЗ

танай _____ -ны № _____ -1

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөө сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ерөө сумын ИТХ-ын "Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай" 115 дугаар тогтоолоор тайлант онд 6,674,551.8 мянган төгрөгийн татварын орлого, 160,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 6,834,551.8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 7,490,933.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 9.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Бугант тосгоны Захирагчийн алба нь дулааны үнэ тариф нэмэгдсэнээс шалтгаалж өмнөх онуудад үүссэн боловч санхүүгийн тайланд тусгаагүй байсан 39,533.2 мянган төгрөгийн түлш, халаалтын зардлын ер төлбөрийг тайлант оны батлагдсан төсвөөс зарцуулж, зардлаар тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Ерөө сумын Засаг дарга нь тайлант онд 11 зорилт, 185 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 84.3 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,618,525.20	4,382,808.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,751,925.10	2,477,110.90
33	АВЛАГА	564,715.50	642,898.20
35	БАРАА МАТЕРИАЛ	301,884.60	1,262,799.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,745,785.40	6,178,054.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,745,785.40	6,178,054.20
39200	Биет хөрөнгө	5,498,757.60	5,931,488.90
39300	Биет бус хөрөнгө	247,027.80	246,565.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,364,310.60	10,560,862.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	123,395.20	262,438.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	123,395.20	262,438.50
41300	Өглөг	123,395.20	262,438.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,240,915.40	10,298,424.00
51	Засгийн газрын хувь оролцоо	9,240,915.40	10,298,424.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,461,774.50	1,461,774.50
51200	Хуримтлагдсан үр дүн	7,195,244.70	8,252,753.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	583,896.30	583,896.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,364,310.60	10,560,862.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,875,464.00	9,715,917.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	5,885,985.90	7,328,327.30
110	Орлогын албан татвар	2,298,478.20	5,988,957.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,298,478.20	6,086,338.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(97,381.00)
113	Хөрөнгийн албан татвар	156,820.60	131,366.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,430,687.10	1,208,002.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	893,188.30	946,257.60
120	Нийтлэг татварын бус орлого	893,188.30	946,257.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,096,289.80	1,441,332.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,173,437.80	7,309,484.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,782,321.40	7,097,275.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,348,232.00	4,277,000.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	702,099.60	1,001,102.50

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,241.50	136,999.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,263,059.70	276,380.30
2104	Хангамж, бараа материалын зардал	167,983.80	120,171.90
2105	Нормативт зардал	55.00	546.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,890.30	78,681.20
2107	Томилолт, зочны зардал	7,107.80	9,053.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,759.90	1,458,331.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,019,034.30	1,195,734.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,434,089.40	2,820,275.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	391,116.40	212,209.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,702,026.20	2,406,432.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,707,064.50	1,347,242.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6,005,038.30	1,059,190.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,249,883.80	-	15,249,883.80
2	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,240,915.40	-	9,240,915.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,245,953.80	-	15,245,953.80
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,930.10)	-	(3,930.10)
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
6	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
8	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
9	Зарласан ногдол ашиг	-	-	-
10	Тайлант үеийн үр дүн	-6,005,038.30	-	-6,005,038.30
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,240,915.40	-	9,240,915.40
12	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,298,424.00	-	10,298,424.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,239,233.40	-	9,239,233.40
14	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,682.00)	-	(1,682.00)
15	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
16	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
17	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
18	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
19	Зарласан ногдол ашиг	-	-	-
20	Тайлант үеийн үр дүн	1,059,190.60	0	1,059,190.60

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

СЭА-2024/04-НА-СТА-ТТЗ

Дансны код	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,397,155.80	9,081,559.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	5,885,985.90	7,328,327.30
110	Орлогын албан татвар	2,298,478.20	5,988,957.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,298,478.20	6,086,338.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(97,381.00)
113	Хөрөнгийн албан татвар	156,820.60	131,366.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,430,687.10	1,208,002.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	121,642.90	41,203.40
1181	Газрын төлбөр	457,088.20	387,559.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,851,956.00	779,240.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	464,980.10	361,446.70
120	Нийтлэг татварын бус орлого	464,980.10	361,446.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,046,189.80	1,391,785.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,369,703.70	6,531,385.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,369,703.70	6,531,385.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,885,547.40	3,711,110.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,646.60	1,001,100.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,241.50	132,532.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,263,059.70	276,380.30
2104	Хангамж, бараа материалын зардал	173,119.30	119,505.90
2105	Нормативт зардал	639.4	546.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,654.30	78,681.20
2107	Томилолт, зочны зардал	7,107.80	9,053.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,705.60	1,488,071.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	558,373.20	605,239.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,484,156.30	2,820,275.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,027,452.00	2,550,173.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,154,794.60	2,764,987.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,154,794.60	2,764,987.70
2200	Дотоод эх үүсвэрээр	2,154,794.60	2,764,987.70
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,154,794.60)	(2,764,987.70)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(60,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	(60,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	872,657.40	(274,814.20)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,879,267.70	2,751,925.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,751,925.10	2,477,110.90

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,246,110.50	6,514,580.40	2,731,530.10	70.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,990,365.80	3,719,831.30	270,534.50	93.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,959,260.20	3,689,201.20	270,059.00	93.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,012,495.60	1,001,100.10	11,395.50	98.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,154.30	132,532.30	2,622.00	98.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,619,474.70	1,516,491.40	102,983.30	93.64
2104	Хангамж, бараа материалын зардал	110,661.90	106,307.70	4,354.2	96.07
2105	Нормативт зардал	4,546.00	546.00	4,000.00	12.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	170,897.90	166,425.30	4,472.60	97.38
2107	Томилолт, зочны зардал	11,543.60	9,053.20	2,490.40	78.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	285,251.00	231,455.30	53,795.70	81.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	609,235.20	525,289.80	83,945.40	86.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,105.60	30,630.20	475.40	98.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,105.60	30,630.20	475.40	98.47
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,935,744.70	2,734,749.10	2,200,995.60	55.41
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	320,000.00	60,000.00	260,000.00	18.75
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,246,110.50	6,628,548.60	2,617,561.90	71.69
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,245,901.40	6,430,208.50	(1,084,307.10)	122.58
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,464,109.10	198,340.20	2,265,768.90	8.05
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,536,100.00	-	(1,536,100.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	341,572.48	(341,572.48)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	455,540.72	(455,540.72)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	43	44	(1)	102.30

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Мөнгөн дүн
------------	----------	------------

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	248,743.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	248,743.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,148.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,198.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,449.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,595.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	147,595.9
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	147,595.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	248,743.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	248,743.9
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,400.0
131103	ЗГНХ, ЭДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,530.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,248.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	151,565.1

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ерөө сумын ТТЗ нь тайлант оны үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэж, төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэхэд оршино.”* гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад

орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,

- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас бие даасан дотоод хяналт, шалгалт

хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ерөө сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан "Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" -ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус сумын ТТЗ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,196,551.9 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,751,925.1	2,477,110.9	(274,814.2)
Авлага	564,715.5	642,898.2	78,182.7
Бараа материал	301,884.6	1,262,799.2	960,914.6
Үндсэн хөрөнгө	5,745,785.4	6,178,054.2	432,268.8

Нийт хөрөнгө	9,364,310.6	10,560,862.5	1,196,551.9
Өр төлбөр	123,395.2	262,438.5	139,043.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,240,915.4	10,298,424.0	1,057,508.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,364,310.6	10,560,862.5	1,196,551.9

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байгаа бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,477,110.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 274,814.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	2,751,925.1	2,477,110.9	(274,814.2)
Төрийн сангийн харилцах	2,751,925.1	2,477,110.9	(274,814.2)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-	-
Дүн	2,751,925.1	2,477,110.9	(274,814.2)

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 1,925,200.6 мянган төгрөг, ОНХС-ийн 333,935.8 мянган төгрөг, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн 96,369.6 мянган төгрөг, ХХС-ийн 121,604.9 мянган төгрөг тус тус тайлагнагдсан байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 642,898.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 78,182.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	29,054.3	39,837.7	10,783.4
Байгууллагаас авах авлага	113,835.3	203,575.6	89,740.3
Хувь хүмүүсээс авах авлага	32,621.3	32,201.2	(420.1)
Хувь хүмүүст олгосон зээл	389,204.6	367,283.7	(21,920.9)
Дүн	564,715.5	642,898.2	78,182.7

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл сумын ЗДТГ-ын 177,204.6 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 26,000.0 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 427,941.8 мянган төгрөгийн, Орон нутгийн ерөнхий орлогын 11,751.8 мянган төгрөгийн авлагууд тайлагнагдсан байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 66.5 хувь буюу 427,941.8 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сан *Лүүнээс 2010-2012 онд олгосон "Итгэлийн зээл"-ийн зээлийн үлдэгдэл 20,820.4 мянган төгрөг байна./*-ийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,262,799.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 960,914.6 мянган төгрөгөөр буюу 4.1 дахин өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	6,694.6	15,785.1	9,090.5
Бичиг хэргийн материал	746.2	-	(746.2)
Аж ахуйн материал	68,776.5	58,770.5	(10,006.0)
Сэлбэг хэрэгсэл	250.0	250.0	-
Түлш, шатах тослох материал	1,990.6	-	(1,990.6)
Барилгын засварын материал	111,710.4	1,022,764.3	911,053.9
Бусад хангамжийн материал	77,516.3	91,029.3	13,513.0
Мал амьтад	34,200.0	74,200.0	40,000.00
Дүн	301,884.6	1,262,799.2	960,914.6

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 960,914.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,513,903.8 мянган төгрөгийн бараа материал худалдаж авсан, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн 1,022,764.3 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ болон 40,000.0 мянган төгрөгийн үхэр, адууг орлого авсан, Дэлхийн зөн ОУБ-аас 287.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан зэрэг нийт 2,576,955.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 508,406.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн 1,107,634.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагад хүлээлгэж өгснөөс шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 8,042,082.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 914,357.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,844,878.1	7,759,235.1	914,357.0
Барилга, байгууламж, орон сууц	3,015,399.5	3,606,926.9	591,527.4

Авто-тээврийн хэрэгсэл	980,233.7	980,233.7	-
Машин тоног төхөөрөмж (компьютер)	420,694.7	478,979.3	58,284.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	138,333.8	143,386.2	5,052.4
Зам гүүрийн байгууламж	853,757.6	865,757.6	12,000.0
Дуусаагүй барилга	-	184,220.0	184,220.0
Бусад үндсэн хөрөнгө	1,436,458.8	1,499,731.4	63,272.6
Биет бус хөрөнгө	282,847.8	282,847.8	-
Программ хангамж	6,560.0	6,560.0	-
Бусад биет бус хөрөнгө	276,287.8	276,287.8	-
Дүн	7,127,725.9	8,042,082.9	914,357.0

Эх сурвалж: Ерөө сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 914,357.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 298,938.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт 615,418.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй дараах төсөл, арга хэмжээнүүдийг орлого авч, бүртгэснээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Сумын ОНХО-аар хэрэгжүүлсэн 276,959.4 мянган төгрөгийн, төсөвт өртөгтэй “Бугант тосгонд наадмын талбай барих”, 195,113.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгонд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх”, 39,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Цагдаагийн албан хаагчдын байр”,
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 59,954.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант ходоод хэсэгт хүүхдийн тоглоомын талбай барих”, 20,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Худаг уст цэг шинээр гаргах” зэрэг төсөл, арга хэмжээнүүдийг орлогод бүртгэж тайлагнасан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 262,438.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 139,043.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	4,467.2	4,467.2
Байгууллагад төлөх өглөг	123,395.2	257,971.3	134,576.1
Дүн	123,395.2	262,438.5	139,043.3

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд байгууллагад төлөх сумын ЗДТГ-ын 137,568.6 мянган төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн 21,265.9 мянган төгрөгийн, барьцаа хөрөнгийн дансны 96,369.5 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн 2,767.3 мянган төгрөгийн, ажилчидтай холбоотой сумын ИТХ-ын нийгмийн даатгалын шимтгэлийн 4,467.2 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 10,298,424.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,057,508.6 мянган төгрөгөөр өссөн байна.

СЭА-2024/04-НА-СТА-ТТЗ

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,461,774.5	1,461,774.5	-
Хуримтлагдсан үр дүн	7,195,244.6	8,252,753.2	1,057,508.6
Өмнөх үеийн үр дүн	13,200,282.9	7,193,562.6	(6,006,720.3)
Тайлант үеийн үр дүн	(6,005,038.3)	1,059,190.6	4,945,847.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	583,896.3	583,896.3	-
Дүн	9,240,915.4	10,298,424.0	1,057,508.6

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,057,508.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Ерөө сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 115 дугаар тогтоолоор 6,674,551.8 мянган төгрөгийн татварын орлого, 160,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 7,490,933.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	6,674,551.8	7,328,327.3	653,775.5	109.8
Хүн амын орлогын албан татвар	5,380,309.0	5,988,957.8	608,648.8	111.3
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	5,395,309.0	5,972,060.2	576,751.2	110.7
Үйл ажиллагааны орлого	25,000.0	41,042.4	16,042.4	164.2
Хөрөнгө борлуулсны орлого	10,000.0	10,813.4	813.4	108.1
Хөрөнгийн орлого/ Хадгаламжийн хүүгийн татварын орлого/	50,000.0	62,422.8	12,422.8	124.8
Хөрөнгийн албан татвар	196,831.8	131,366.8	(65,465.0)	66.7
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	35,000.0	19,278.6	(15,721.4)	55.1
Бууны албан татвар	3,500.0	2,310.0	(1,190.0)	66.0
Малд ноогдуулах албан татвар	158,331.8	109,778.2	(48,553.6)	69.3
Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар	90,000.0	41,203.4	(48,796.6)	45.8
Улсын тэмдэгтийн хураамж	55,000.0	9,335.5	(45,664.5)	17.0
Хог хаягдлын хураамжийн орлого	25,000.0	19,064.3	(5,935.7)	76.3
ТТАМАТөлбөр	10,000.0	12,803.6	2,803.6	128.0
Газрын төлбөр	326,464.0	387,559.0	61,095.0	118.7

Газрын төлбөр	275,436.0	333,955.2	58,519.2	121.2
Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	51,028.0	53,603.8	2,575.8	105.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	680,947.0	779,240.1	98,293.1	114.4
Ойн нөөц ашигласны төлбөр	670,133.0	770,566.3	100,433.3	115.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,014.0	1,692.2	678.2	166.9
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	9,800.0	6,981.6	(2,818.4)	71.2
Татварын бус бусад орлого	160,000.0	162,606.5	2,606.5	101.6
Нэр заагдаагүй бусад орлого	10,000.00	34,114.6	24,114.6	341.1
Хүү, торгуулийн орлого	150,000.00	128,491.9	(21,508.1)	85.7
НИЙТ ДҮН	6,834,551.8	7,490,933.9	656,382.1	109.6

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 576,751.2 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 16,042.4 мянган төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн орлого 12,422.8 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 58,519.2 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 100,433.3 мянган төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 24,114.6 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлогын гүйцэтгэлээр үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, малд ноогдуулах албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, хүү, торгуулийн орлого, хог хаягдлын хураамжийн орлогууд тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- ✓ **Үйл ажиллагааны орлого:** ХХААХҮЯ-аас 2022 оны улаан буудай болон ноосны урамшуулал олгосонтой холбоотой,
- ✓ **Хүн амын орлогын албан татварын орлого:** “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн өмнөх оны ХХОАТ-ын өр төлбөрийг барагдуулсантай холбоотой,
- ✓ **Хөрөнгийн орлого /Хадгаламжийн хүүгийн татварын орлого/:** Тайлант онд иргэдийн хадгаламжийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой,
- ✓ **Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлого:** Сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн асфальт бетон, хайрган замын ажлуудад ашиглагдсан элс, хайрганы төлбөрийн орлого нэмэгдсэнтэй холбоотой,
- ✓ **Газрын төлбөр:** Тайлант онд дуудлага худалдаагаар иргэн, аж ахуйн нэгжид газар олголт нэмэгдсэнтэй холбоотой,
- ✓ **Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого:** Өмнөх оны мод бэлтгэх эрхийн төлбөрийг барагдуулсантай холбоотой,
- ✓ **Нэр заагдаагүй бусад орлого:** Шүүхийн шийдвэрийн дагуу хураагдсан хөрөнгө, бараа материалыг дуудлага худалдаагаар борлуулсантай холбоотой байна.

Тасарсан орлогууд:

- ✓ **Үл хөдлөх хөрөнгө болон бууны албан татвар, малд ногдуулах албан татвар:** Орлогын бүрдүүлэлтэд хяналт тавиагүйгээс шалтгаалсан,
- ✓ **Улсын тэмдэгтийн хураамж:** Байгаль цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан ойн дагалт баялгийн нөөцийг тогтоогоогүйгээс шалтгаалсан,
- ✓ **Хог хаягдлын хураамж:** Хог хаягдлын орлогын төвлөрүүлэлт хангалтгүйгээс,
- ✓ **Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр:** Төлөвлөсөн байгалийн ургамал ашиглаж байсан аж ахуйн нэгж, байгууллагууд нь тайлант онд Хүдэр сумын нутаг дэвсгэрээс ургамал бэлтгэсэнтэй холбоотой,
- ✓ **Хүү, торгуулийн орлого:** Орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 6,240,161.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 4,599,531.8 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлогыг 108,120.9 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 2,797,334.5 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 153,095.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,01,529.2 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 90,000.0 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс 150,000.0 мянган төгрөг, ХХС-ийн урьд оны үлдэгдлээс 83,000.0 мянган төгрөг зэрэг нийт 8,993,611.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 141 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 115 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 2,343,140.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 6,834,551.8 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлогыг 108,120.9 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 2,029,893.4 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих 153,095.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,198,994.4 мянган төгрөг, хандив тусламжийн орлогыг 1,386,100.0 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 90,000.0 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс 150,000.0 мянган төгрөг, ХХС-ийн урьд оны үлдэгдлээс 83,000.0 мянган төгрөг зэрэг нийт **12,033,755.5** мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, **9,246,110.5** мянган төгрөгийг зарцуулан, **2,787,645.0** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 7,490,933.9 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 1,198,994.4 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 111,040.0 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 87,300.1 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 2,029,893.4 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 153,095.0 мянган төгрөг, ХХС-ийн урьд оны үлдэгдлээс

83,000.0 мянган төгрөг, хандив тусламжийн орлогоос 1,536,100.0 мянган төгрөг зэрэг нийт **12,690,356.8** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн, **2,787,644.8** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 19 хөтөлбөрийн 35 арга хэмжээг санхүүжүүлэхээр **12,033,755.5** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,990,365.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 4,935,744.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 320,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:

<i>/мянган төгрөгөөр/</i>					
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	249,256.1	195,087.0	54,169.1	78.2
2	Засаг даргын тамгын газар	3,543,267.3	2,906,122.0	637,145.3	82.0
3	Бугант Захирагчийн алба	669,343.9	634,277.6	35,066.3	94.7
4	Сум дундын Ойн анги	196,955.3	167,788.4	29,166.9	85.2
5	Орон нутгийн хөгжлийн сан	2,896,521.2	1,272,675.0	1,623,846.2	43.9
6	Хоршоо хөгжүүлэх сан	323,000.0	62,013.8	260,986.2	19.2
7	Ерөө ЕБС	556,330.1	510,049.5	46,280.6	91.7
8	Бугант ЕБС	226,121.4	223,646.2	2,475.2	98.9
9	Ерөө Эрүүл мэндийн төв	84,056.7	82,903.1	1,153.6	98.6
10	Бугант Эрүүл мэндийн төв	62,753.5	62,581.8	171.7	99.7
11	Ерөө Цэцэрлэг	123,943.5	102,785.8	21,157.7	82.9
12	Бугант Цэцэрлэг	129,124.9	125,598.0	3,527.0	97.3
13	Ерөө Соёлын төв	73,753.0	59,750.0	14,003.1	81.0
14	Бугант Соёлын төв	111,683.6	109,302.2	2,381.4	97.9
	Нийт дүн	9,246,110.5	6,514,580.4	2,731,530.1	70.5

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 5,231,214.1 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 111,040.0 мянган төгрөг / Сумын ЗДТГ-ын 420.0 мянган төгрөг, Ерөө бүсийн сум дундын Ойн ангийн 110,101.1 мянган төгрөг, ОНХС-аас өмнөх онд илүү олгосон 518.9 мянган төгрөгийн санхүүжилтийг буцаан авсан. /, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 87,300.1 мянган төгрөг, ОНХС-аас 1,198,994.4 мянган төгрөг нийт **6,628.548.6** мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **6,514,580.4** мянган төгрөг буюу 70.5 хувьтай байгаа нь урсгал зардлыг 270,534.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 2,200,995.6 мянган төгрөгөөр, ХХС-ийн 260,000.0 мянган төгрөг /Тайлант онд зээлийн шалгуур хангасан зээл хүсэгч байхгүйгээс зээл олгогдоогүй байна./ -ийг тус тус хэмнэсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 11,395.5 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 2,622.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 102,983.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 4,354.2 мянган төгрөгөөр, нормативт зардал 4,000.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 4,472.6 мянган төгрөгөөр, томилолтын зардал 2,490.4 мянган төгрөгөөр,

бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 53,795.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 83,945.4 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 475.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 14 төсөл, арга хэмжээнд 2,019,732.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 1,462,074.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 557,658.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 3 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй, 2 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 12 төсөл, арга хэмжээнд 1,468,709.4 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 1,272,675.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 196,034.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 1 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 19,248.4 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 63,530.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 151,565.1 мянган төгрөг, хандивын орлого 14,400.0 мянган төгрөг зэрэг нийт **248,743.9** мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс тээвэр, шатахууны зардалд 13,198.2 мянган төгрөг, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардалд 5,500.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 80,449.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 2,000.0 мянган төгрөг зэрэг нийт **101,148.0** мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст **147,595.9** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих 24 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын төсөл, арга	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний нийт	Үүнээс:

хэмжээний эх үүсвэр	Тоо	Дүн	Шууд худалдан авалт		Харьцуулалты н арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХО	14	2,039,223.5	4	75,505.2	2	92,514.2	9	1,871,204.1
Сумын ОНХС	10	1,414,709.4	7	117,020.0	1	60,247.2	2	1,237,442.2
Засаг даргын мөрийн хөтөлбөр	5	157,514.0	4	63,514.0	-	-	1	94,000.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ерөө сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 130 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,173,435.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 51,734.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 7,309,484.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 73,094.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд тус төвлөрүүлэн захирагч нь харьяа байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар тайлант оны эцэст батлагдсан төсвийг 29.6 хувиар хэмнэсэн байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шатахууны зардлыг хэмнэх зорилгоор автомашинуудад цэнхэр дугаар авсан,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй зэрэг төсвийн захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

Тайлант онд Бугант тосгоны захирагчийн захирамжаар “Аймгийн начин” цолтой бөх, шагнал авсан 6 иргэнд хүндэтгэл үзүүлсэн гэх үндэслэлээр Захирагчийн албаны нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын батлагдсан төсвөөс нийт 680.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”, 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	182	179	3	-
2	Засаг даргын Тамгын газар	182	179	3	-
3	Бугант тосгоны Захирагчийн алба	182	174	8	-
4	Ерөө бүсийн Ойн анги	182	180	2	-
	Нийт дүн	728	712	16	-

Сумын ТТЗ-ийн дүнгээр нийт мэдээлбэл зохих 728 мэдээллээс 712 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж өгөв.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	5,398.0	1	5,398.0	100
Албан шаардлага	5	318,785.7	5	318,785.7	100
Зөвлөмж	5	6,931.0	5	6,931.0	100
Нийт дүн	11	331,114.7	11	331,114.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Бугант тосгоны Захирагчийн алба нь тайлант оны төсөвт батлагдаагүй орон тоо буюу биеийн тамирын арга зүйчээр Ж.Төгсбаярыг томилон ажиллуулсан байна.

Иймд “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар цаашид гүнзгийрүүлэн авч үзэх нь зүйтэй юм.

2. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 11,100.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг залрууллаа. Үүнд:

Залруулсан алдаа:

- Ерөө бүсийн сум дундын Ойн анги нь тайлант онд худалдан авсан 10,000.0 мянган төгрөгийн модны үрийг бусад хангамжийн материалын дансанд бүртгэж тайлагнасныг тусгай зориулалтын материалын дансанд, 1,100.0 мянган төгрөгийн 2 ширхэг хаалгыг үндсэн хөрөнгөнд бүртгэж, тайлагнасныг засварын материалын дансанд бүртгэж залрууллаа.

Залруулаагүй алдаа:

Аудитаар илэрсэн нийт 184,220.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдааг залруулах зөвлөмж өглөө. Үүнд:

- Тайлант онд сумын ОНХО-аар хэрэгжүүлж эхэлсэн боловч дуусаагүй “Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийх” төсөл, арга хэмжээний 79,200.0 мянган төгрөг, “Ухаалаг худаг” төсөл, арга хэмжээний 100,000.0 мянган төгрөг, “Шаазгайтын хэсэгт трансфарматор худалдан авах” төсөл, арга хэмжээний 5,020.0 мянган төгрөг зэрэг нийт 184,220.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бараа материалын дансанд бус үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх дуусаагүй 3 төсөл, арга хэмжээг бараа материалын дансанд бүртгэж, 2024 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт 60,314.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,122.9 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 59,191.4 мянган төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Албан хаагчдын албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож, сумын ЗДТГ нь 497.0 мянган төгрөг, Бугант тосгоны Захирагчийн алба нь 266.0 мянган төгрөгийг тус тус илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.”*, 20.2.5 дахь *“... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Сумын ИТХ нь 3 албан хаагчийн 2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухайн үеийн үндсэн цалингаас бус 7 дугаар сард нэмэгдсэн цалингаас тооцож 359.9 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.”* 20.2.5 дахь *“... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зардлаас мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй хяналтын пост байрлуулах гэр худалдан авахад 3,500.0 мянган төгрөг, сумын 100 жилийн ойг угтаж уулзалт, тэмцээн зохион байгуулах зардалд 14,865.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас хэрэгжүүлэхээр батлагдсан 10,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй *“Ерөө сумын ЭМТ-ийн цахилгааны монтажийг солих”* төсөл, арга хэмжээг сумын орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас санхүүжүүлж, хөтөлбөр хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан *“Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”*-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын ЗДТГ-т иргэний бүртгэлийн тоног төхөөрөмж, цэцэрлэгт принтер худалдан авахад 1,697.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3.1.2 дахь "... энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Сумын ЗДТГ нь орон тоонд батлагдаагүй нотариат болон хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан гэх үндэслэлээр хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Дашдэлэг /2,537.1 мянган төгрөг/, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан ажилтан Б.Алтанцэцэг /6,075.1 мянган төгрөг/ нарт үндсэн цалингийн 40 хувиар тооцож, нийт 8,612.2 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооны хүрээнд ажиллагсдын цалин хөлсийг тогтоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.5 Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс сумын ИТХ нь 4,467.2 мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:" 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ..." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.6 Бугант тосгоны Захирагчийн алба нь нэмэлт санхүүжилтийн дансаар аж ахуйн нэгж, иргэдээс 14,400.0 мянган төгрөгийн хандивын орлого төвлөрүүлж, баяр наадмын зардалд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь "Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно.", 25.2.1 дэх "эмнэлгийн үйлчилгээ", 25.2.2 дахь "бүх шатны боловсролын үйлчилгээ", 25.2.3 дахь "соёлын үйлчилгээ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.7 Бугант тосгоны Захирагчийн захирамжаар “Аймгийн начин” цолтой бөх, шагнал авсан 6 иргэнд хүндэтгэл үзүүлсэн гэх үндэслэлээр Захирагчийн албаны нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшлын зардлын батлагдсан төсвөөс нийт 680.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “*Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшил: “Байгууллагын дотоод журамд заасны дагуу **албан хаагчид** ... олгох мөнгөн шагнал, урамшуулал, эсхүл журамд заасан нөхцөлөөр олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.8 Бугант тосгоны Захирагчийн алба нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас авто машины засвар үйлчилгээний зардалд 970.0 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тус ТЕЗ-ийн харьяа орон нутгийн байгууллагууд нь санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна*”, 8.1.5 дахь “*санхүүгийн тайлангийн тодруулга*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 09 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сум дундын Ойн анги	2	11,100.0			2	11,100.0	2	11,100.0				
Сумын ЗДТГ	1	184,220.0			1	184,220.0			1	184,220.0	1	184,220.0
Дүн	3	195,320.0			3	195,320.0	2	11,100.0	1	184,220.0	1	184,220.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ерөө сумын ТТЗ	12	60,314.3	3	1,122.9	8	59,191.4	1	-				
Дүн	12	60,314.3	3	1,122.9	8	59,191.4	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
							Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны мэдээллийг ИТХ нь 3, ЗДТГ нь 3, Бугант тосгоны Захирагчийн алба нь 8, Ойн анги нь 2 зэрэг нийт 16 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-						1	-
Дүн	1	-						1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1	-						1	-